МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 08 өдөр Дугаар А/469 Мөрөн сум

Залуучуудын хөгжлийн аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 11 дүгээр зүйлийн 11.1.2, 12 дугаар зүйлийн 12.1.2, 12.3.2, 12.3.3, 12.3.4, 13 дугаар зүйлийн 13.1.1, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, 15.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1.2, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдын 2023 оны А/112 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн залуучуудын нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, залуучуудын хөгжих, хөдөлмөрлөх боломжийг өсгөх зорилгоор залуучуудын хөгжлийг дэмжих аяныг 2023 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн нэг сарын хугацаанд зохион байгуулсугай.

2. Тус аяныг "Хүний эрхийг дээдэлсэн нийгэм цогцлооход залуучуудын бүтээлч хамтын оролцоо" сэдвийн хүрээнд зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, аяныг зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.

3. Төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, гүйцэтгэл үр дүнг 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор тайлагнаж ажиллахыг ажлын хэсэг (Ч.Дашбаяр)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т даалгасугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023

671001006

Аймгийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр
сарын 08-ны өдрийн А/469 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН САРЫН АЯН ЗОХИОН
БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Э.Улам-Өсөх
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Ажлын хэсгийн гишүүд:

Б.Батбилгүүн
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Н.Төмөрхуяг
(Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга)

Б.Цолмонбаяр
(Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйлдвэр, худалдаа үйлчилгээний албаны дарга)

Ц.Мөнхсоёл
(Аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын шинжлэх ухаан, технологи, инноваци, мэргэжлийн болон дээд боловсрол хариуцсан ахлах арга зүйч)

Б.Түмдоддаваа
(Аймгийн Эрүүл мэндийн газрын өсвөр үеийн эрүүл мэнд, сэтгэл зүй хариуцсан мэргэжилтэн)

В.Шинэцэцэг
(Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын ажил мэргэжлийн чиг баримжаа, ажилд зуучлах үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн)

А.Дашцоож
(Аймгийн Цагдаагийн газрын сэтгэл зүйч, дэслэгч)

П.Даваадулам
(Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгч)

Е.Мягмарсүрэн
(Хөвсгөл аймаг дахь Политехник коллежийн нийгмийн ажилтан)

Б.Мөнхжаргал
("Карьер донор" хөдөлмөрийн бирж)

Ажлын хэсгийн нарийн бичиг:

Ч.Дашбаяр
(Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга)

-------oOo------

Аймгийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр
сарын 08 -ны өдрийн А/146.. дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН САРЫН АЯНЫ
ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Залуучуудын хөгжлийг дэмжих ажлыг тэгш хүртээмжтэй болгох, залуучуудыг сонсох, тэдний өмнө тулгамдсан асуудлыг тэдний өөрсдийнх нь оролцоотой шийдвэрлэх, бодит шийдэлд хүрэх, залуучуудын утга учиртай оролцоог нэмэгдүүлэх, залуучууд эвлэлдэн нэгдэх, хөгжих, хөдөлмөрлөх боломжийг нэмэгдүүлэхэд оршино.

Сэдэв, уриа: "Хүний эрхийг дээдэлсэн нийгэм цогцлооход залуучуудын бүтээлч хамтын оролцоо".

Хэрэгжүүлэх хугацаа: 2023 оны 9 дүгээр сарын 10-наас 10 дугаар сарын 10 хүртэл.

Хамтран ажиллах байгууллага: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Эрүүл мэндийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Хөвсгөл аймаг дахь Политехник коллеж, "Карьер донор" хөдөлмөрийн бирж, Сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар

№	Арга хэмжээ	Хэрэгжүүлэх арга зүй	Хугацаа	Хариуцах эзэн
1	Залуучуудын хөгжлийн сарын аяны нээлт зохион байгуулах.	Аймаг, болон 24 сумын Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, залуучуудын оролцоог хангаж, аяны хүрээнд хэрэгжих ажлыг иргэд, олон нийтэд хүргэх замаар шинэлэг, бүтээлч арга хэлбэрээр явуулна.	IX/12	Аймгийн ГБХЗХГ, ЗХТ, ажлын хэсэг
2	Сумын Залуучуудын дэд чуулганыг зохион байгуулах.	Аяны уриан дор залуучуудын чуулга уулзалтыг сум бүр зохион байгуулж, залуучуудын өмнө тулгамдаж буй асуудал, шийдлийг тодорхойлж аймгийн чуулганд санал, зөвлөмж оруулах.	IX/20	Сумын ИТХ, ЗДТГ, Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл
3	Аймгийн Залуучуудын чуулган зохион байгуулах.	Залуучуудын чуулга уулзалтыг сум, баг, төрийн бус байгууллага, залуучуудын төлөөллийг оролцуулан зохион байгуулж, залуучуудыг сонсож, шийдвэр гаргах түвшинд тэдний дуу хоолойг хүргэж, шийдвэр гаргана. Зохион байгуулалт, арга хэлбэрийг оновчтой сонгоно.	IX/29	Аймгийн НБХ, ГБХЗХГ, ажлын хэсэг

4	“Шинэ цагийн илгээлтийн эзэд” арга хэмжээ зохион байгуулах.	Залуу малчин, тариаланчдад туслах залуучуудын хөдөлгөөн өрнүүлэх замаар аймаг орны бүтээн байгуулалт, хөгжилд залуучуудын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх.	IX/10-IX/30	Аймгийн НБХ, ГБХЗХГ, ЗХТ, ХХААГ, Политехник коллеж, Сумдын ИТХ, ЗДТГ, ажлын хэсэг
5	“Залуус” явуулын үйлчилгээ хэрэгжүүлэх.	Сумдын ЗХСЗ үйл ажиллагаатай танилцах, зөвлөн туслах, залуучуудад хөдөлмөр эрхлэлт, хууль эрх зүй, сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх, гэр бүлийн боловсрол, амьдрах ухаан, хувь хөгжлийн сургалт зохион байгуулах байдлаар залуучуудад хүрч үйлчлэх.	IX/18-IX/22	Аймгийн НБХ, ГБХЗХГ, ЗХТ, БШУГ, ХХҮГ, УБХ, ЦГ, ЭМГ, ажлын хэсэг
6	Гэрлэх ёслол, хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулах.	Залуу гэр бүл, гэрлэх насны залуучууд, гэрлэлтээ шинээр бүртгүүлэх залуучуудыг хамруулна. Гэрлэх ёслол, гэрлэлтийн гэрчилгээ гардуулах, сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээ хийгдэнэ.	IX/10-X/10	Аймгийн НБХ, ГБХЗХГ, ЗХТ, УБХ, ажлын хэсэг, Сумдын ЗХСЗөвлөл
7	“Залуучуудад ээлтэй шийдвэр” арга хэмжээ авах.	Залуучуудын хөгжил, оролцоог дэмжих, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэсэн бодит үр дүнд чиглэсэн шийдвэрүүд бүх шатны ИТХ, Засаг даргаар дамжиж гарах. Санал санаачилга, төсөл оруулах.	IX/10-X/10	Аймгийн ГБХЗХГ, Залуучуудын хөгжлийн төв, залуучууд, ажлын хэсэг.
8	“Залуучуудын хөгжлийн цахим төв”-ийг сурталчлах арга хэмжээ авах.	Залуучуудын хөгжлийн төвийн үйлчилгээний мэдээллийг QR кодоор дамжуулан бүх шатны ЗДТГ, их, дээд сургуулиуд, коллеж, ЕБС-иудад хүргэх, сурталчлах.	IX/10-X/10	Аймгийн ГБХЗХГ, Залуучуудын хөгжлийн төв
9	Байгууллагын дэргэдэх Залуучуудын хөгжлийн зөвлөлүүдийн ажлыг идэвхжүүлэх, шинээр байгуулах.	ЗХЗ-үүдийн ажлыг идэвхжүүлэх ажлыг шинэлэг, бүтээлч байдлаар явуулж, дүгнэн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/72 дугаар тушаалын хүрээнд агентлаг, байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэд зөвлөл шинээр байгуулах ажлыг хэрэгжүүлэх.	IX/10-X/10	
10	“Хөдөлмөрч залуу” арга хэмжээ зохион байгуулах.	Арга хэмжээний удирдамж, хөтөлбөрийг ажлын хэсэгтэй хамтран оновчтой төлөвлөнө. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн боловсролыг сурталчлах, зорилтот бүлгийн залуучуудад хандсан ажлуудыг хэрэгжүүлж дүгнэнэ.	IX/18-наас	Аймгийн НБХ, ГБХЗХГ, ЗХТ, ХХҮГ, БШУГ, Политехник коллеж, ТББ, Ажлын хэсэг.
11	Сайн дурын ажилтан залуучуудыг бэлтгэх, дэмжих.	Нийт 300 сайн дурын ажилтан залуучуудыг бэлтгэх. Удирдамж, ажиллах чиглэлийг оновчтой гаргана.	IX, IX сард	Аймгийн НБХ, ГБХЗХГ, ЗХТ, ажлын хэсэг, сумдын ЗДТГ.

12	“Нэг залуу- Нэг алхам” арга хэмжээ зохион байгуулах.	Сум бүр нэг залууг сонгож, амьдралын чанарыг дээшлүүлэх төлөвлөгөө боловсруулж, үе шаттай хэрэгжүүлэх, бодит үр дүнд хүрэх.	IX-XII сард	Сумдын ЗДТГ, ЗХСЗ, ажлын хэсэг.
13	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх бэлтгэх.	Өсвөр үе, залуучуудад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт зохион байгуулах, зөвлөх бэлтгэх.	IX/18-наас	Аймгийн НБХ, ГБХЗХГ, ЗХТ, “Карьер донор” хөдөлмөрийн бирж, Ажлын хэсэг.
14	“Залуучууд судлал” онол практикийн бага хурал зохион байгуулах.	Залуучуудын хөгжил, тэдний тулгамдаж буй асуудал, өнөөгийн нөхцөл байдлын талаар судалгаа, шинжилгээ, шийдэл бүхий хурал байна.	X/06	Аймгийн НБХ, ГБХЗХГ, ЗХТ, БШУГ, Ажлын хэсэг

Хүрэх үр дүн:

1. Залуучуудын өмнө тулгамдаж буй асуудлыг тэдний оролцоотой илрүүлж, шийдэл-арга замыг тодорхойлж, шийдвэр гаргах түвшинд хүргэж, залуучуудын шийдвэрт нөлөөлөх бодит оролцоог хангасан байна.
2. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн боловсролыг сурталчлах, зорилтот бүлгийн залуучуудад хандсан ажлууд хэрэгжиж бодит үр дүн гарсан байна.
3. 24 сумын залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагаа эрчимжиж, залуучуудын хөгжлийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээ өргөжнө.
4. Нийт залуучуудын 10-аас доошгүй хувьд хууль эрх зүй, сэтгэл зүй, хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсролын чиглэлээр мэдээлэл зөвлөгөө өгсөн байна.
5. Гэр бүлийн боловсрол, амьдрах ухаан, хувь хүний хөгжлийн сургалтад нийт залуучуудын 20-оос доошгүй хувийг хамруулсан байна.
6. 50 залуу гэр бүлийг “Гэрлэх ёслол хүндэтгэл”-ийн арга хэмжээнд хамруулж, гэр бүлийн үүрэг хариуцлагыг ухамсарлуулсан байна.
7. Байгууллагын дэргэдэх Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, шинээр залуучуудын хөгжлийн 25 зөвлөл байгуулсан байна.
8. Зорилтот бүлгийн 50 залуугийн хөдөлмөр эрхлэлтийн чадамжийг нэмэгдүүлсэн байна.
9. Сайн дурын ажилтнаар 300 залуучуудыг бэлтгэж, чадавхжуулсан байна.
10. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох 150 зөвлөх бэлтгэгдсэн байна.

-------oOo--------